

Сангийн сайдын 2013 оны 05 дугаар
сарын 31-ний өдрийн 125 дугаар
тушаалын 1 дүгээр хавсралт

ХЭНТИЙ АЙМАГ БИНДЭР СУМ

ҮНИЙН САНАЛ АВАХ ЖИШИГ БАРИМТ БИЧИГ

**(ХАРЬЦУУЛАЛТЫН АРГААР БАРАА
ХУДАЛДАН АВАХАД АШИГЛАНА)**

2024 оны 06 дугаар сарын 20

Хэнтий аймаг Биндэр сум ЗДТГазар

Хэнтий аймаг Биндэр сум ЗДТГазар

Огноо: 2024/06/20

ХАРЬЦУУЛАЛТЫН АРГААР
АЖИЛ ГҮЙЦЭТГҮҮЛЭХ
ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН
БАРИМТ БИЧИГ

Тендер
шалгаруулал
тын нэр:

3-р багийн төвийн тохижилт, засвар

Тендер
шалгаруулал
тын дугаар:

№: ХЭАБСЗДТГ/20240201010

ОРШИЛ

“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хууль, тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Сангийн яамнаас боловсруулсан энэхүү үнийн санал авах жишиг баримт бичгийг Захиалагч байгууллага 50,000,000 төгрөгөөс доош төсөвт өртөгтэй бараа нийлүүлэх гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар сонгох болон шууд гэрээ байгуулах үед мөрдөнө.

Үнийн санал авах жишиг бичиг баримтын заалтуудад зарчмын бус өөрчлөлт оруулж тухайн барааг худалдан авах ажиллагаанд тавигдах шаардлагад нийцүүлбэл зохино. Эдгээр өөрчлөлтийг хийхдээ дараах удирдамжийг дагаж мөрдөнө

1. Үнийн санал авах баримт бичгийг худалдан авах бараа буюу төслийн онцлог байдалд нийцүүлэн энэхүү жишиг баримт бичгийн дагуу бэлтгэнэ.
2. Захиалагч налуу үсгээр хаалтанд бичсэн жишээ, зааврын оронд тохирох үг өгүүлбэр, тоо хэмжээ, хувь, валют зэргийг бөглөнө. Үнийн санал ирүүлэгчийн бөглөх хэсгийг захиалагч бөглөхгүй орхино.
3. Үнийн санал авах жишиг баримт бичгийн зүүлт/тайлбар болон санамж нь захиалагчид заавар өгөх зорилготой тул үнийн санал авах баримт бичгийг бэлтгэхдээ тэдгээрийг хасна.

Энэхүү тендерийн баримт бичигтэй холбоотой асуулт ирүүлэх, тайлбар эсвэл нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар холбоо барина уу.

Сангийн яамны Хууль, худалдан авах ажиллагааны бодлогын газар

Утас: 267416, 267648

Web: www.e-procurement.mn

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Хэнтий аймаг Биндэр сум ЗДТГазар нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **3-р багийн төвийн тохижилт, засварыг гүйцэтгэх** тухай санал ирүүлэхийг урьж байна.

Тохижилт засварын гүйцэтгэлийн техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Тохижилт засварын гүйцэтгэлийн саналыг **[2024/06/26 10:00]**-аас өмнө ***Хэнтий Аймаг Биндэр СЭМТ 111 тоотод Их эмч О.Даваасоёмбо Утас 98081177 tender.gov.mn*** хаягаар ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2024/06/26** ны өдрийн **[10:30]**¹-т нээнэ.

Дотоодны давуу эрх тооцох эсэх.²

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Хэнтий Аймаг Биндэр СЭМТ 111 тоотод Их эмч О.Даваасоёмбо Утас 98081177

¹ Тендерийг хүлээж авах эцсийн хугацааг дууссанаас хойш 1 цагийн дотор байна.

² Захиалагч тендер шалгаруулалтад давуу эрхийн зөрүү хэрэглэхгүй бол, энэ өгүүлбэрийг хасч оронд нь “Монгол Улсын гарал үүсэлтэй бараанд давуу эрхийн зөрүү тооцохгүй” гэж бичнэ.

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа**

1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**

2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.

2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.

2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**

3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:

 - (а) Үнийн санал;
 - (б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
 - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
 - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
- 4. Тогтмол үнэ**


4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.

5. **Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд**
- 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
- 5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
6. **Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**
- 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.
7. **Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
8. **Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. **ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<p>Сүүлийн 2023 оны жилийн санхүүгийн тайлан /шаардлагатай бол аудитын дүгнэлтийн хамт/;</p> <p>Сүүлийн 1 жилийн туршлагын мэдээлэл /гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/;</p> <p>Тендерт оролцогч тухайн ажилд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай.</p> <p>Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - ААНБ-ын гэрчилгээ - Татварын газарын лавлагаа - Нийгмийн даатгалын лавлагаа.
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: Хэнтий Аймаг Биндэр СЭМТ 111 тоотод Их эмч О.Даваасоёмбо Утас 98081177</p> <p>Огноо: 2024 оны 06 дүгээр сарын 26-ны өдөр]</p> <p>Цаг: 10 цаг 00 минут</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг Хэнтий Аймаг Биндэр СЭМТ 111 тоот</p> <p>Огноо: 2024 оны 06 дүгээр сарын 26 -ны өдөр]</p> <p>Цаг: 10 цаг 30 минут</p>
ТӨӨЗ 2.3	<p>Дөрөвдүгээр бүлгийн маягтуудаас гадна эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох дараах баримт бичиг, материалыг өөрийн тендертээ нууцлахгүй ирүүлнэ.</p>
ТӨӨЗ 6.2	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: 3-р багийн төвийн тохижилт, засвар</p>

Дөрөв. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

СУМЫН ЗАСАГ ДАРГА  БАТЛАВ
Э.МӨНХ-ОЧИР

БАГИЙН ТӨВИЙН ШИНЭ БАЙР ОРООЖ БОЛГОХ ХИЙГДЭХ АЖИЛ

1. Байшинг дээврийн банзыг тэгшилж, Вааран хээтэй хүрэн өнгийн төмрөөр дээвэрлэнэ, гадана талын дээврийн хөндийг шувуу орхооргүй битүү хар хавтангаар таглаж, янзыг цагаан будгаар будах.
2. Байшинд хундаам цутгаж дотор нь дүүргэлт хийн чигжээд 15 см зузаантай бетонон шал цутгах, шалыг резинэн будгаар 2 давхарлан будах.
3. Цонхонд холоод хийж 2.5- 1.5 хэмжээтэй 3 ш цонхыг урд хананд суулгах "Биндэр суманд хийсэн цонх байх"
4. Зүүн талд хаалагны холоод зангидан 1ш сайн чанарын төмөр хаалга суулгах.
5. Таазанд 10 см хөөс чийг тусгаарлагчтай хийж наанаас битүү панэйлаар бүрэн, цахилгааны мантаж гэрэл суулгана.
6. Ханыг гадна доторгүй бүтэн зүлгэж модны будгаар будана.
7. Цонх хаалганд бүгдэнд нь янз хийж цагаанаар будах.
8. Гүйцэтгэгч тал нь бүх шаардагдах материал тоног төхөөрөмжийг өөрсдөө авчирч ажлыг гэрээнд заасан цаг хугцаанд бүрэн гүйцэд хийн хүлээлгэж өгнө.
9. 3 митр нүхтэй ,2 митр өндөртэй, 1.5 митр өргөн, төмөр дээвэртэй, дотрологоотой модон жорлон 1ш хийнэ.

БЗД  Ж.ГАНЗОРИГТ